

**Нислэгийн цаг уурын төвийн  
2019 оны 04 дүгээр сард хийсэн ажлын тайлан**

2019.04.25

**Зорилт:**

Нислэгт цаг агаарын бүх төрлийн урьдчилсан болон бодит мэдээ мэдээллээр шуурхай үйлчлэх, нислэгийн зөрчил саатлын тоог бууруулах, албан хаагчдын мэргэжил, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилт тавин ажилласан. Төвийн 2019 оны 4 дүгээр сарын ажлын гүйцэтгэл 100 хувьтай байна.

Мэдээлэл үйлчилгээний талаар:

2019 оны 04 дүгээр сард “Чингис хаан” олон улсын нисэх буудал орчмын богино хугацааны урьдчилсан мэдээ /TAF/ мэдээ 131, урт хугацааны урьдчилсан мэдээ 81, районы урьдчилсан мэдээ 137, угталтын урьдчилсан мэдээ 98, өндрийн салхины урьдчилсан мэдээ 160, аэродромын урьдчилсан мэдээ 40, SIGMET 49, Тосонцэнгэл нисэх буудал орчмын богино хугацааны TAF 40, хөөрөлтийн урьдчилсан мэдээ 130, Ханбумбат нисэх буудлын TAF 103, Овоот нисэх буудлын TAF 19, бусад нисэх буудал орчмын урьдчилсан мэдээ 30 удаа тус тус гаргаж, олон улсын 464, орон нутгийн 312, онцгой ба тусгай үүргийн 17 нислэгт 182 чиглэлийн урьдчилсан мэдээ болон бодит мэдээ 1364, уур амьсгалын ажиглалтын мэдээ 248, харьцуулсан ажиглалт 23, аюул 2, агаар мэдээ-2 мэдээ, мэдээллээр үйлчилсэн байна. Хэрэглэгчдийн хүсэлтээр цаг агаарын зөвлөгөөг утсаар болон цахимаар өгч байна. Төв орон нутгийн 3652 бодит мэдээ, 1261 урьдчилсан мэдээг хүлээн авч дамжуулсан байна. 4 дүгээр сард Европын дунд хугацааны тоон прогнозын зураг, Япон, Солонгосын прогноз зураг, болон өндрийн цаг агаарын зураг /850гПа, 700гПа, 500гПа, 300 гПа, ОТ 1000:500/, газрын цаг агаарын зураг, орчны цаг агаарын бодит зураг, онцгой үзэгдлийн зураг, олон улсын нислэгт зориулж салхи температурын орны зураг, FY-2C болон Himawaricast японы хиймэл дагуулын үүлний зураг тус тус хүлээн авч мэдээ зохиолт болон нислэгийн үйлчилгээний ажилд ашигласан. Дэлхийн бүсийн урьдчилсан мэдээлэх систем /WAFS/-ийн бүтээгдэхүүнүүд хэвийн.

36 цагийн урьдчилалтай тоон загварын үр дүнг боловсруулж, 7 хоногийн төлөв гаргахад зориулж 168 цагийн урьдчилалтай тоон загварын үр дүн, стандарт өндрүүдийн салхи температурын орны зургуудыг тус тус урьдчилсан мэдээ зохиолт, нислэгийн үйлчилгээнд ашиглаж байна.

Чингис хаан ОУНБ орчмын урьдчилсан мэдээний таарц, нислэгийн саатал:

Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад богино хугацааны урьдчилсан мэдээний таарц 1,99%-иар, урт хугацааны урьдчилсан мэдээний дундаж таарц 1.11%-иар өссөн үзүүлэлттэй байна.

“Чингис хаан” олон улсын нисэх буудал орчмын цаг агаарын байдлаас шалтгаалсан нислэгийн саатлын судалгаа: 4 дүгээр сард нийт 24 саатал гарсан байна. Үүнд: таарсан 19, таараагүй урьдчилсан мэдээ-5.

*Нислэгийн саатлыг үзэгдэл элементээр нь үзүүлвэл:* Баруун хойдын салхитайгаас 17 нислэгийн гарсан бөгөөд урьдчилсан мэдээ таарсан 14, таараагүй-3, Зүүн өмнөдийн салхитайгаас 7 нислэгийн гарсан. Урьдчилсан мэдээ таарсан 5, таараагүй-2, “Чингис хаан” олон улсын нисэх буудал орчмын цаг агаарын бодит ажиглалтын мэдээ-1074, Уур амьсгалын ажиглалт-200, харьцуулсан ажиглалт-12, аюул-8, агаар-8, сарын дундаж мэдээ-2 удаа зохиосон.

#### Орон нутагт:

Олон улс болон орон нутгийн агаарын шугамд нислэг үйлдсэн үндсэн буудлын 312, бэлтгэл буудлын 556 нислэгт, нислэгийн чиглэлийн урьдчилсан /НИ-5/ мэдээ 72, угталтын урьдчилсан мэдээ 6, буудал орчмын бодит мэдээ 1024, буудал орчмын урьдчилсан мэдээ 371, районы урьдчилсан мэдээ 421, аэродромын урьдчилсан мэдээ 254, зурвасын гадаргын байдлын мэдээг 6 дамжуулж үйлчилсэн. Орон нутагт цаг агаараас шалтгаалсан 4 нислэгийн саатал гарсан бөгөөд Алтай нисэх буудалд цасан шуургатай байснаас цуцалсан-1, Өлгий нисэх буудалд салхитай байснаас цуцалсан-1, Ханбумбат нисэх буудалд шороон шуургатай байснаас хүлээсэн-1, буцсан-1 нислэгүүд саатсан байна. Замын агаар муугаас 3 нислэг цуцалсан байна.

#### Бусад ажлын талаар:

- Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2019 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн А/98 дугаар тушаалаар төвийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, дүрэм, зохион байгуулалтын бүтэц, албан тушаалтнуудын ажлын чиг үүрэгт өөрчлөлт оруулан шинэчлэн баталсан.
- Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 5 дугаар тогтоолын дагуу төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдлийг шалгаж сайжруулах үүрэг чиглэлийн дагуу ЦУОШГ-ын хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтанд хүний нөөцийн судалгаа гаргаж хүргүүлсэн. Шинэчлэгдэн батлагдсан Төрийн албан хаагчийн анкет, хувь хүний намтар зэргийг албан хаагчдаас авч хувийн хэргийг бүрдүүлж байна.
- 4 дүгээр сарын 8,10-нд 3 дугаар сарын болон 1 дүгээр улирлын товч тайланг ЦУОШГ-ын Байгууллагын архив, тайлан, мэдээ хариуцсан мэргэжилтэн газрын байгууллагын архив, тайлан, мэдээ хариуцсан мэргэжилтэнд хүргүүлсэн.
- 11-нд Төрийн албаны хүний нөөцийн судалгааг газрын Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэнд цахимаар хүргүүлсэн.
- 15-нд албан хаагчдын боловсролын судалгаа гаргаж, газрын Санхүү, төлөвлөлт, хамтын ажиллагааны хэлтсийн даргад цахимаар хүргүүлсэн.
- Шилэн дансны нэгдсэн системд 2019 оны 4 дүгээр сарын байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, шилжилт хөдөлгөөний мэдээлэл болон төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн тушаал шийдвэрийн мэдээллийг оруулсан. Төвийн даргын А/06, А/08 дугаар тушаалуудыг (Сургалтын төлбөр гаргах тухай) хавсралтын хамт оруулсан.

- Ази, Номхон далайн бүсийн агаарын навигацийн төлөвлөлт, хэрэгжилт /MANPING/-ийн “Өргөтгөсөн удирдах зөвлөл”-ийн анхдугаар хуралд оролцсон. 4 сарын 08-нд MANPING-ийн ажлын хэсгийн “Цаг уурын мэдээлэл солилцоо, хэрэгцээ, үйлчилгээний баг”-ийн хурлын бэлтгэл ажлын хүрээнд ажлын хэсгийн гишүүд хурлаар хэлэлцүүлэх асуудлуудыг ярилцаж хурлын хөтөлбөрийг боловсруулж, ажлын төлөвлөгөөг нарийвчлан хэлэлцсэн.
- Хамтын ажиллагааны хүрээнд 4 дүгээр сарын 05-нд Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албанаас зохион байгуулсан “Нислэгийн яриа” уулзалтад хаврын улирлын цаг агаарын онцлог, цаг агаарын төлвийн талаар товч танилцуулга хийсэн. Уулзалтын үеэр цаг уурын мэдээ, үйлчилгээтэй холбоотой гарсан санал хүсэлтийг дарга, зөвлөлийн гишүүдэд танилцуулсан.
- Тоон загварчлалын сервер дээр WRF загварын боловсруулсан үр дүнг post process, интерполяци хийж, “Grads” цаг уурын зургийн программ дээр зурж байна.

Сургалт дадлага, хурал, семинар:

Нэр	Албан тушаал	Ямар чиглэлээр сурсан	Хугацаа
А.Баярсайхан	Жижүүр цахилгаанчин	“Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн дагуу аюулгүй ажиллагааны мэргэшлийн үнэмлэх /групп/ олгох сургалт	2019.04.18-наас 24 цаг
Ш.Аюушжав	Сүлжээ, мэдээлллийн сангийн инженер	Монголын Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн менежментийн хүрээлэн (OSHMI)-д ХАБЭА-н ажилтаны 40 цагийн хөтөлбөр	2019.04.22-ноос 40 цаг
А.Баярмаа	Сүлжээ, мэдээлллийн сангийн инженер	Үндэсний мэдээлэл технологийн академид программ хангамж мэдээлэл технологийн 3 сарын сургалт	2019.03.05-наас эхэлсэн
Ш.Аюушжав	Сүлжээ, мэдээлллийн сангийн инженер	Үндэсний мэдээлэл технологийн академид вэб мастер мэдээлэл технологийн 3 сарын сургалт	2019.03.05-наас эхэлсэн

**Орон нутгийн УЦУОШТ-үүд болон нисэх буудлуудаас**

Б.Айнур	Синоптик инженер	Баян-Өлгий аймгийн УЦУОШТ	2019.01.23-02.11, 03.25-04.04
Х.Жавзандулам	Техникч	Овоот нисэх буудал	2019.04.04-04.12
А.Лхагвасүрэн	Техникч	Хэнтий аймгийн УЦУОШТ	2019.04.08-04.18
Д.Алтанзул	Синоптик инженер	Булган аймгийн УЦУОШТ	2018.04.09-нөөс
Г.Түвшинбаяр	Синоптик инженер	Өмнөговь аймгийн УЦУОШТ	2018.04.16-наас

Агаарын тээврийн Хэрэглэгч байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 3 сарын 28-нд МИАТ ХК, 4 сарын 02-нд Аэромонгол ХХК, 4 сарын 03-нд Геосан ХХК-ийн нисэх баг болон диспетчер нарт хаврын улирлын цаг агаарын онцлог нислэгт аюултай үзэгдлүүд, TAF, METAR, нислэгт ашиглах зураг мэдээ зэрэг сэдвээр нийт 8 цагийн сэргээх, давтан сургалт, 4 сарын 11-нд МИАТ ХК-ийн Нислэг үйлдвэрлэл зохицуулалт, инженерингийн хэлтсийн ажилтнуудад Шилжилтийн улирлын цаг агаарын онцлог, нислэгт үзүүлэх нөлөө сэдвээр МҮХ-ийн дарга 2 цагийн сургалтуудыг тус тус явуулсан.

***Дүгнэлт:***

Нислэгийн цаг уурын төвийн 2019 оны 4 дүгээр сарын шинжилгээ, мэдээлэл үйлчилгээ, тоног төхөөрөмжийн ажиллагаа “Хэвийн” явагдсан.

Нислэгийн цаг уурын төвийн  
Захиргаа, дотоод хяналт, чанарын хэлтэс